



РНХ-ИЙН БҮТЭЦ БА УУРГИЙН НИЙЛЭГЖИЛТ


РНХ нь дан гинжнээс бүтдэгээрээ ДНХ-ийн молекулаас ялгаатай. Дөрвөн төрлийн азотлог суурь болон сахар нь ДНХ-ийн нуклеотидоос ялгаатай.



РНХ нь Зөөврийн РНХ (**зРНХ**), рибосомын РНХ (**рРНХ**), мэдээллийн РНХ (**мРНХ**) гэсэн гурван төрөлтэй.



мРНХ: Мэдээллийн РНХ нь бөөмд байгаа удамшлын мэдээлэл болон тухайн нийлэгжих уургийн мэдээллийг ДНХ-ээс хуулбарлан эсийн сийвэнд хүргэнэ. Ингэж ДНХ-ийн мэдээллийг мРНХ өөртөө буулган нийлэгжихийг транскрипц гэдэг. ДНХийн мэдээллийн дагууд үүссэн мРНХ-ийн гурван триплетээс бүтсэн нэг амин хүчлийг кодлох хэсгийг **кодон** гэнэ.




рРНХ: Рибосомын РНХ нь эсийн бөөмхөнд нийлэгжин, эсийн сийвэнд уурагтай нэгдэн рибосомыг үүсгэдэг. Рибосом нь уургийг нийлэгжүүлэгч гол эрхтэнцэр бөгөөд рибосом дээр мРНХ-ийн кодын дагууд тохирох амин хүчлүүд хоорондоо холбогдон анхдагч бүтэцтэй уургийн молекул үүсэхийг **трансляц** гэдэг. Энэ үйл явцад олон тооны рибосом оролцдог, тэдгээрийг нийтэд нь **полисом** гэж нэрлэдэг.



зРНХ: Зөөврийн РНХ нь уураг нийлэгжих рибосомд мРНХ-ийн кодлогдсон мэдээллийн дагууд тохирох амин хүчлийг зөөвөрлөн хүргэх үүрэгтэй. Уураг нь 20 амин хүчлээс бүтдэг болохоор эдгээр амин хүчил бүрийг зөөвөрлөдөг 20 янзын зРНХ байдаг. Эсийн сийвэнд чөлөөт амин хүчил, зөөврийн РНХ байдаг.

зРНХ-ийн нэг үзүүрт амин хүчил, харин нөгөө үзүүрт мРНХ-ийн кодонтой хамжаа зарчмаар тохирох гурван азотлог суурь байна. Түүнийг **антикодон** гэж нэрлэдэг. Дараагийн зРНХ нь кодонтой тохирох амин хүчлийг авчирч, хоёр амин хүчлийг хооронд нь пептидийн холбоогоор энзим холбоно. Рибосом мРНХ-ийн дараагийн кодоныг уншиж, гурав дахь амин хүчил холбогдоно. Энэ үйл явц нь мРНХ-ийн зогсох кодон болох УАА, УАЦ, УГА-г унших хүртэл полипептид гинж угсрагдана.



МЭДЛЭГ БАТАТГАХ ТЕСТ

1. ДНХ ба РНХ-н ялгаатай бүтцийг нэрлээрэй?

- А. Азотлог суурь,сахар
- Б. Фосфор,сахар
- В. Сахар,өөх тос
- Г. Фосфор, өөх тос

2. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү?

РНХ-ийн найрлагад.....,.....,.....гэсэн азотлог сууриуд багтана. РНХ нь.....,.....байрладаг.....гинж юм. РНХ нь бөөмийн нүх сүвээр кариоплазмаас.....-д ирж,нийлэгжүүлэх үүрэгтэй.

3. РНХ нь 3 төрөл ба тус бүрийн үүргийг тодорхойлон бичнэ үү?

.....

4. ДНХ болон РНХ гинжний ялгааг бичээрэй?

	ДНХ	РНХ
Гинжний тоо		
Сахар		
Азотлог суурь		
Үүрэг		